



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/107

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гэр хорооллын цэвэр бохир усны шугам сүлжээ /Ховд аймаг Жаргалант сум Алагтолгой, Бугат, Буянт, Хайрхан баг/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Дарга: Т.Дэлгэрсайхан - Аймгийн Засаг даргын орлогч
- Гишүүдэд: Д.Батцэнгэл - Мал эмнэлэгийн газрын дарга
- Т.Бямбатөмөр - Төрийн бус байгууллагын төлөөлөл
- Ц.Соёлмаа - Иргэний төлөөлөл
- Нарийн бичгийн дарга: Х.Дэмид - Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Т.Дэлгэрсайхан/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Х.Дэмид/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД